

Зарим хүнд ердийн даатгалын актуарчийн  
үйл ажиллагаа эрхлэх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 39.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан ”Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам“-ын 2.1, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол даатгал” ХХК-ийн ажилтан Мөнхбаатарын Од (регистрын дугаар ЖЭ80091816), “Прайм женерал даатгал” ХХК-ийн ажилтан Очирбатын Батжаргал (регистрын дугаар УГ75061600), “Миг даатгал” ХХК-ийн ажилтан Эрдэнэчулууны Энхчимэг (регистрын дугаар ЧК83012800) нарт ердийн даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг тус тус олгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар (С.Ганболд), олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ